



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Айраг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ДГА-2022/04/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Дорноговь аймаг 2022 он	Дарга, тэргүүлэх аудитор: Т.Ган-Өлзий	
	Утас: 70522734	Цахим хаяг: dornogovi@audit.gov.mn
	Аудитын менежер:	У.Оюунтүлхүүр
	Утас: 70523020	Цахим хаяг: oyuntulkhuur.u@audit.gov.mn
	Ахлах аудитор:	Э.Энхцэцэг
Аудитор:		Т.Мөнхтогтох
		Цахим хаяг: munkhtogtokht@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

44103 Дорноговь аймаг, Сайншанд сум,
3 дугаар баг, Орон нутгийн өмчийн III байр,
Утас: (705) 2-27-34
Вэб сайт: dornogovi@audit.gov.mn

2021.08.26 № 1-8/21

танай _____ -ны № _____ -т

АЙРАГ СУМЫН ИРГЭДИЙН
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА Н.БАТ-ЭРДЭНЭ ТАНАА

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Айраг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Айраг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Т.ГАН-ӨЛЗИЙ

Нэг. Санхүүгийн ба төсвийн гүйцэтгэлийн тайлангийн гол үзүүлэлтүүд

		/сая төгрөгөөр/	
	Үзүүлэлт	2020.12.31	2021.12.31
Санхүүгийн байдлын тайлан			
	Эргэлтийн хөрөнгийн дүн	4.5	2.7
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	4.5	8.8
	Нийт хөрөнгийн дүн	9.0	11.5
	Нийт өр төлбөрийн дүн	-	-
	Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	9.0	11.5
	Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	9.0	11.5
Санхүүгийн үр дүнгийн тайлан			
	Үйл ажиллагааны орлогын дүн	73.6	75.3
	Үйл ажиллагааны зардлын дүн	73.5	72.7
	Үйл ажиллагааны үр дүн	0.1	2.6
	Үйл ажиллагааны бус үр дүн	-	-
	Үйл ажиллагааны нийт үр дүн	0.1	2.6
Мөнгөн гүйлгээний тайлан			
	Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	73.6	72.7
	Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	73.6	69.8
	Үйл ажиллагааны ЦМГ	-	2.9
	Хөрөнгө оруулалтын ЦМГ	-	2.9
	Санхүүгийн ажиллагааны ЦМГ	-	-
	Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	-	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан			
	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-
	Тайлант оны үр дүн	4.2	2.6
	Эцсийн үлдэгдэл	8.9	11.5
Төсвийн гүйцэтгэлийн тайлан			
	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	62.8	63.3
	Урсгал зардал	62.8	63.3
	Хөрөнгийн зардал	-	-
	Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	63.6	63.3
	Орон нутгийн төсвөөс санхүүжих	63.6	63.3
	Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас	-	-

Хоёр. Байгууллага, түүний үйл ажиллагаа

Айраг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь зорилгоо дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Монгол Улсын хуулиудад заагдсан эрх, үүргийн биелэлтийг ханган нутгийн өөрөө удирдах ёсны чадавхыг бэхжүүлэх, төрийн үйлчилгээний чанар хүртээмжийн байдалд төлөөлөгчдөөр дамжуулан иргэдийн хяналт, оролцоог дээшлүүлэх, иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийн баталгааг бий болгох бодлого шийдвэрийг боловсруулан хэрэгжүүлэх, эхэлсэн ажлуудын тогтвортой байдлыг хангаж ажиллах.

Байгууллагын 2021 онд дэвшүүлсэн зорилт:

- Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Тэргүүлэгчдийн хуралдааны үйл ажиллагааг шуурхай хангах, иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд хуулиар олгогдсон бүрэн эрх, үүргийн хүрээнд орон нутаг болон иргэдийн ашиг сонирхолд нийцүүлсэн бодлого боловсруулж оновчтой шийдвэр гарган ажиллана.
- Төлөөлөгч, хурлын хороодыг идэвхжүүлэн Хуралд хуулиар олгогдсон хяналт шалгалтын ажлын үр дүнг дээшлүүлэн хуулийн хэрэгжилт, сумын эдийн засгийн чадавхыг сайжруулахад нөлөөлж ажиллана.
- Төрийн дээд шагнал, одон медаль болон “Алдарт эх” одонгоор иргэдийг шагнуулахаар ирүүлсэн хүсэлтийг хэлэлцэж уламжлах, иргэдэд шагнал олгох, лавлагаа мэдээлэл өгөх, шагнах үйл ажиллагаатай холбоотой хууль журмын мэдээллийг шуурхай хүргэж ажиллах.
- Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгсдийг цагаатгах, тэдэнд нөхөх олговор олгох тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэн нөхөх олговор олгохтой холбоотой асуудлаар иргэдэд үйлчилгээ, мэдээлэл, лавлагаа өгч ажиллах.
- ИТХ-аас иргэдэд зориулсан уралдаан тэмцээн, тэмдэглэлт өдөр, хууль тогтоомжийг сурталчлах нөлөөллийн ажлуудыг хийн Хурал, иргэдийн хамтын ажиллагааг сайжруулах.
- Мэдээллийн технологийн бодлогын хэрэгжилтийг зохион байгуулах, мэдээллийн сан бүрдүүлэх, статистик мэдээ гаргах, хэрэглэгчдийг мэдээллээр хангах.

Айраг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Төр, эдийн засаг, нийгмийн бодлогын үйл ажиллагааг үзүүлэх.

Гурав. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Тайлант хугацаанд оруулбал зохих 149 мэдээллээс хугацаандаа оруулсан 149 мэдээлэл, хугацаа хоцроосон мэдээлэл байхгүй байна.

Дөрөв. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Анхаарал татахуйц асуудал байхгүй байна.

Тав. Аудитын илрүүлэлт:

Аудитаар нийт 0.3 сая төгрөгийн 2 алдаа зөрчил илэрснээс, 0.3 сая төгрөгийн 1 алдааг залруулж, 1 зөвлөмж өгсөн.

Залруулсан алдаа

Нэмэлт санхүүжилтийн төсвийн гүйцэтгэлийн тайланд 0.3 сая төгрөгийн орлогыг дутуу тайлагнасныг залруулав.

Зөвлөмж

1. Ажил гүйлгээний ангитай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Засгийн газрын 2021 оны А/43 дугаар "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" тогтоолын 1.6 "Засгийн газрын шийдвэр гарснаас бусад баяр ёслол, тэмдэглэлт ой, урлагийн наадам, спортын уралдаан тэмцээн, салбарын өдөр, аялал зугаалга зэргийг зохион байгуулахгүй байх" заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй, 2.6 сая төгрөгийн гүйлгээ хийсэн байна.

1.2. Өгсөн зөвлөмж:

Засгийн газрын 2021 оны А/43 дугаар "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллах.

6.1 Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн мэдээлэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1			1			
	НИЙТ	1	1			1			

6.2 Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл:

/сая төгрөгөөр/

№	Төсвийн захирагчийн ангилал	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
A	1	2	3	4	5	6	7	8	9	10	11
1	ТШЗ	2	0.3	1	0.3	-	-	-	-	1	-
	НИЙТ	2	0.3	1	0.3	-	-	-	-	1	-